

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

Агуулга, бүлгийн нэр	Хуудасны дугаар
1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	4
2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	6
2.1 Төсвийн шууд захирагчийн тайлан	7
2.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан	8
2.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.4 Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан	9
3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	10
3.1 Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг	10
4. НИЙЦЛИЙН АУДИТ	11
4.1 Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа	11
4.2 Аймгийн болон Замын-Үүд сумын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, иргэн, ААНБ-аас төвлөрүүлсэн хандивын зарцуулалт	11
5. ИТХ-ЫН ЗАХИАЛГА, ӨӨРИЙН САНААЧИЛГААР ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ	12
5.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө	12
5.2 Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл	12
5.3 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үр дүн	13
6. ДОТООД АЖИЛ	13
6.1 Дотоод сургалт	13
6.2 Архив, бичиг хэрэг	14
6.3 Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа	15
6.4 Дотоод зохион байгуулалтын бусад асуудал	15
6.5 Хүний нөөц, шагнал урамшуулал	16
6.6 Шинэ санал, санаачилга	16
7. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	16
8. ДҮГНЭЛТ, САНАЛ	17
8.1 Дүгнэлт	17
8.2 Санал	18
Хавсралт	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ГА	Гүйцэтгэлийн аудит
ДГА	Дорноговь аймаг
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ММНБИ	Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НА	Нийцлийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТАГ	Төрийн аудитын газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨААН	Төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААН	Төрийн өмчийн аж ахуйн нэгж
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБАК	Хараат бус аудитын компани
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

I.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/02 дугаар тушаалаар Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэн баталсан.

Мөн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/19 дугаар тушаалаар аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын орон тоо, албан тушаалын жагсаалт батлагдаж, тус газрын бүтцэд 1 орон тоо нэмэгдэн нийт 12 орон тоотой болсон .

Тайлант хугацаанд үндсэн 11, гэрээт 3 нийт 14 ажилтантай 1350 хүн-өдөр, 3792 илүү цаг ажиллаж, батлагдсан бүтцийн хүрээнд төрөлжсөн аудит хариуцсан 3 нэгж болон дэмжих үйлчилгээний нэгжид, дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер, жолооч, бичиг хэрэг, нягтлан бодогч, үйлчлэгч тус бүр 1, ахлах аудитор 2, аудитороор 6 ажилтан ажиллаж байна.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар Төрийн аудитын байгууллагын 2021 онд дэвшүүлсэн “Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх” зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, стратегийн хүрээнд нийт 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс эхний хагас жилд хэрэгжүүлж дуусах 12, эхэлсэн боловч хэрэгжих хугацаа болоогүй 3, гүйцэтгэх хугацаа болоогүй 8, жилийн турш хэрэгжүүлэх 22 арга хэмжээ байна.

Төрийн байгууллагын аудитын чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд хэрэгжүүлбэл зохих 12 арга хэмжээг төлөвлөгөөт цаг хугацаанд нь чанартай бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.

Аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант оны эхний хагас жилд гүйцэтгэлийн аудит 2, өмнөх оноос шилжиж ирсэн нийцлийн аудит 1, санхүүгийн тайлангийн аудитаар нийт 206 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитыг бүрэн дуусгахаар төлөвлөсөн. Мөн тайлант хугацаанд эхэлж, дараа улирал дамжих гүйцэтгэх өөрийн санаачилгат гүйцэтгэлийн аудит 2, нэгдсэн удирдамжаар хийгдэх гүйцэтгэл, нийцлийн 3 аудитын үе шатны ажил хийгдэхээр тусгагдсан.

Тайлант хугацаанд дуусгахаар төлөвлөсөн гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн тайлангийн аудитыг Төсвийн тухай хууль болон аудитын төлөвлөгөө хөтөлбөрт тусгасан цаглабрын хугацаанд бүрэн гүйцэтгэж, улирал дамжин хийгдэх гүйцэтгэлийн 2 аудит хуваарийн дагуу тайлагналын үе шатны ажил хийгдэж, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх 3 аудитын төлөвлөгөө хөтөлбөр ирээгүйгээс аудит эхлээгүй байна.

2021 оны эхний хагас жилд аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Алдаа зөрчлийн утгаар	Нийт		СТА		ГА		НА	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Орлого бүрдүүлэлттэй холбоотой	13	2.9	12	2.9	1			
2	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой	5		5					
3	НББ, тайлагналтай холбоотой	429	37,359.2	428	35,223.1	1	2,136.1		
4	Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой	11	1,538.0	7	88.4	4	1,449.6		
5	Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	221	11,425.9	207	11,228.0	11	197.9	3	
6	Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой	56	283.1	39	283.1	12		5	
7	Худалдан авалттай холбоотой	6	1.1	6	1.1				
8	Зориулалт бус зарцуулалттай холбоотой	25	64.4	25	64.4				
9	Бусад	10	182.7	10	182.7				
Нийт		776	50,857.3	739	47,073.7	29	3,783.6	8	0

Аудитаар нийт 50,857.3 сая төгрөгийн 776 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 37,278.7 сая төгрөгийн 413 алдаа зөрчлийг залруулж, 27.5 сая төгрөгийн зөрчилд 21 төлбөрийн акт тогтоож, 5,594.0 сая төгрөгийн зөрчилд 74 албан шаардлагыг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Мөн 7952.4 сая төгрөгийн зөрчилд 264 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 3 албан шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн, 4.7 сая төгрөгийн зөрчилтэй 1 байгууллагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх саналыг МУ-ын Ерөнхий аудиторт хүргүүлсэн.



Тайлант оны эхний хагас жилд хэрэгжвэл зохих 26.1 сая төгрөгийн 19 төлбөрийн актын биелэлт 73.7 хувь, 2560.2 сая төгрөгийн 32 албан шаардлагын биелэлт 93.8 хувь, 5807.8 сая төгрөгийн 99 зөвлөмжийн хэрэгжилт 60.0 хувьтай байна. Холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна.


Мөн өмнөх оны үлдэгдэл 17.7 сая төгрөгийн 19 төлбөрийн актаас 0.9 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 5184.3 сая төгрөгийн 14 албан шаардлагаас 186.9 сая төгрөгийн 3 албан шаардлага тайлант хугацаанд хэрэгжсэн.

Өмнөх оны эхний хагас жилийн статистик мэдээгээр хугацаа хэтэрсэн 17,071.1 сая төгрөгийн 261 акт, албан шаардлага, зөвлөмж байсан бол тайлант онд 15,741.6 сая төгрөгийн 189 акт, албан шаардлага зөвлөмж үлдэгдэлтэй байгаа нь өмнөх үетэй харьцуулахад үлдэгдэл 1,329.5 сая төгрөгөөр буюу 8.0 хувиар буурсан байна.

Тайлант хугацаанд төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг хангуулж, орон нутгийн төсөвт нийт 11.0 сая төгрөгийг төвлөрүүлэн, 11.0 сая төгрөгийн 19 санхүүгийн үр өгөөж, санхүүгийн бус 1 үр өгөөжийг тус тус хүлээн зөвшөөрүүлж ажилласан.

II. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ


Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 221 байгууллага, тусгай сангуудыг аудитад хамруулахаас 15 байгууллагад итгэл үзүүлэн, нийт 206 төсөв захирагч, сан, ТБОНӨААН-ийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийлээ. Үүнээс 47.5 хувь буюу 98 тайланг Төрийн аудитын газар, 52.5 хувь буюу 108 тайланг ХАК-аар гүйцэтгүүллээ.



Санхүүгийн тайлангийн аудитыг ТАГ-ын нийт 5 аудитор, гэрээт аудитораар 2 хүн гүйцэтгэж, 798 хүн-өдөр, 1092 илүү цаг ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/81 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг үндэслэн хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулж “Ингүүмэл жаргалант аудит” ХХК, “Есөн хангай аудит” ХХК, “Гэрэлт хөхийн тэнцвэр” ХХК тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн 106, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 14, төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 8, засгийн газрын тусгай сангийн 4, нийт 133 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, төсвийн шууд захирагчийн 44, сангийн 29, тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийлээ. Аудитаар нийт 127 байгууллагад “Зөрчилгүй”, 5 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгсөн. Доорх графикт санхүүгийн тайлангийн аудитын хэлбэрийг сүүлийн 3 жилээр харуулав.



Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 47,073.7 сая төгрөгийн 739 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 37,278.7 сая төгрөгийн 413 алдааг залруулж, 22.7 сая төгрөгийн зөрчилд 20 төлбөрийн акт тогтоон, 3,260.0 сая төгрөгийн зөрчилд 67 албан шаардлага, 6507.6 сая төгрөгийн зөрчилд 236 зөвлөмж хүргүүллээ. Мөн өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, төлбөрийн актыг барагдуулаагүй 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлж, 4.4 сая төгрөгийн зөрчилтэй 1 байгууллагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр холбогдох баримтыг хуулийн дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүллээ.

Тайлант хугацаанд 6.2 сая төгрөгийн 16 төлбөрийн акт хэрэгжиж, биелэлт 88.8 хувь, 2732.1 сая төгрөгийн 33 албан шаардлага хэрэгжиж, тайлант оны эхний хагас жилд хэрэгжвэл зохих албан шаардлагын хэрэгжилт 93.7 хувьтай, 704.7 сая төгрөгийн 59 зөвлөмж хэрэгжиж, тайлант оны эхний хагас жилд хэрэгжвэл зохих зөвлөмжийн биелэлт 60.0 хувьтай байна.

Өмнөх оны эхний хагас жилийн статистик мэдээгээр хугацаа хэтэрсэн 11,437.9 сая төгрөгийн 184 акт, албан шаардлага, зөвлөмж байсан бол тайлант онд 7,457.6 сая төгрөгийн 148 акт, албан шаардлага зөвлөмж үлдэгдэлтэй байгаа нь байгаа нь өмнөх үетэй харьцуулахад үлдэгдэл 3,980.3 сая төгрөгөөр буюу 35.0 хувиар буурсан байна.

Тайлант онд тогтоосон төлбөрийн актаас 6.3 сая төгрөгийн 16 санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлээд байна.

2.1 Төсвийн шууд захирагчийн тайлан

Аудитад 165 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан, 14 сум хөгжүүлэх сангийн тайлан, 15 орон нутгийн хөгжлийн сангийн тайланг хамруулахаас 15 санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 179 төсвийн шууд захирагчийн 2020 оны санхүүгийн тайланг аудит хамрууллаа. Үүнээс 106 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 73 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэлээ. Тус аудитаар 101 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 4 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Тайлант хугацаанд Сайншанд сумын Захирагчийн ажлын алба, 2 сумын ИТХ, 14 сумын соёлын төв, 26 цэцэрлэг, орон нутгийн хөгжлийн 15 сан, сум хөгжүүлэх 14 сангийн 2020 оны санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөн, бүрэн хэрэгжүүлсэн.

Аудитаар Сайншанд сумын ИТХ, Алтанширээ сумын ЗДТГ, Аймгийн Орон нутгийн өмчийн газар, Сайншанд сумын 7-р цэцэрлэгт тус тус “Хязгаарлалттай” санал дүгнэлт, Аймгийн мал эмнэлгийн газарт “Сөрөг” санал дүгнэлтийг өглөө.

Төсвийн шууд захирагчийн 95 санхүүгийн тайлангийн аудитыг төрийн аудитын байгууллага, 99 санхүүгийн тайлангийн аудитыг ХАК гүйцэтгэсэн

Төсвийн шууд захирагчийн тайланд 28,981.7 сая төгрөгийн 664 алдаа, зөрчил илрүүлж, 24,219.2 сая төгрөгийн 391 алдааг аудитын явцад залруулж, 22.7 сая төгрөгийн зөрчилд 20 төлбөрийн акт тогтоож, 3064.8 сая төгрөгийн зөрчилд 61 албан шаардлага хүргүүлж, 1670.3 сая төгрөгийн зөрчилд 189 зөвлөмж өгч, өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, төлбөрийн актыг барагдуулаагүй 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 4.7 сая төгрөгийн зөрчилтэй 1 байгууллагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр холбогдох баримтыг хуулийн дагуу МУ-ын Ерөнхий аудиторт хүргүүлээ.

Тайлант хугацаанд тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжөөс 6.2 сая төгрөгийн 16 төлбөрийн акт барагдаж, 2664.8 сая төгрөгийн 32 албан шаардлага, 508.3 сая төгрөгийн 44 зөвлөмж хэрэгжсэн байна. Нийт 1,135.0 сая төгрөгийн 139 акт албан шаардлага, зөвлөмжийн хугацаа болоогүй хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Өмнөх оны эхний хагас жилийн статистик мэдээгээр хугацаа хэтэрсэн 3821.2 сая төгрөгийн 157 акт, албан шаардлага, зөвлөмж байсан бол тайлант онд 1,815.5 сая төгрөгийн 123 акт, албан шаардлага зөвлөмж үлдэгдэлтэй байгаа нь байгаа нь өмнөх үетэй харьцуулахад үлдэгдэл 2,005.7 сая төгрөгөөр буюу 52.4 хувиар буурсан байна.

2.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан

Аудитаар 14 сумын санхүүгийн нэгтгэсэн тайланг хамруулахаас бүрэн хамруулж аудитаар 14 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлтийг өглөө. Тайлант хугацаанд Засгийн газрын ХЭДС, НДС, Халамжийн сан /орон нутаг/, Халамжийн сан/улсын төсөв/-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийхээр төлөвлөн, бүрэн хэрэгжүүлж 4 тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 14 сумын болон ХЭДС, НДС-н санхүүгийн тайлангийн аудитыг төрийн аудитын байгууллага, Халамжийн сан /орон нутаг/, Халамжийн сан/улсын төсөв/-ийн санхүүгийн тайлангийн аудитыг хувийн аудитын компани тус тус гүйцэтгэлээ.

Аудитаар илэрсэн зөрчлийг ангилан харуулбал:

- Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 17.0 сая төгрөгийн 2 алдаа
- Орлого бүрдүүлэлттэй холбоотой 3 зөрчил,
- Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой холбоотой 3 зөрчил.
- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 6 зөрчил

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 118.6 сая төгрөгийн 14 алдаа зөрчил илрүүлж, 17.0 сая төгрөгийн 2 алдааг залруулан, 1.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, 100.1 сая төгрөгийн 10 зөвлөмжийг хүргүүллээ.

Өмнөх оны эхний хагас жилийн статистик мэдээгээр хугацаа хэтэрсэн 658.9 сая төгрөгийн 2 зөвлөмж байсан бол тайлант онд 36.1 сая төгрөгийн 2 зөвлөмж үлдэгдэлтэй байгаа нь өмнөх үетэй харьцуулахад үлдэгдэл 622.8 сая төгрөгөөр буюу 94.5 хувиар буурсан байна.

Тайлант хугацаанд өгсөн 2 албан шаардлага, 9 зөвлөмжийн хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй бөгөөд өмнөх оны 1 зөвлөмж, тайлант оны 1 зөвлөмж хэрэгжиж хугацаа болоогүй зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд 14 төсвийн төвлөрүүлэн захирагчийн, 124 орон нутгийн төсөвт болон тусгай шилжүүлгийн, 7 ОНӨХХК, 30 сангуудын, нийт 175 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн.


ТЕЗ-ийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт 5253.8 сая төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс 907.3 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулан, 122.6 сая төгрөгийн 1 албан шаардлага 4223.9 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж хүргүүлэн ажиллалаа. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг дурдвал:

- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын байр ашиглалтын зардлын төсвийг бодитой төлөвлөөгүй,
- Харьяа байгууллагуудын алдаа, зөрчлийн дүн буураагүй, давтагдах шинжтэй
- 2020 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардалд босоо тогтолцоотой байгууллагуудад хөрөнгө оруулалтын ажил хийхээр баталсан байна.
- Аймгийн төрийн сан авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй

Аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 83,818.4 сая төгрөгийн орлого, 82,560.1 сая төгрөгийн зарлага, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1400.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2658.3 сая төгрөгийг аудитаар баталгаажууллаа.

Өмнөх оны хугацаа хэтэрсэн 1 зөвлөмж хэрэгжээгүй үлдэгдэлтэй тайлант онд тогтоосон албан шаардлага болон зөвлөмжийн хэрэгжилтийн хугацаа болоогүй тул хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

2.4. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан



Аудитад 8 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг хамруулахаас 8 санхүүгийн тайланг хамруулж, 8 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Замын-Үүд НААҮГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлтийг өглөө.

ТБОНӨААН-ийн 1 аж ахуйн нэгжид төрийн аудитын байгууллага, 7 аж ахуйн нэгжид хувийн аудитын компани санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэсэн.

Аудитаар 12,719.1 сая төгрөгийн 49 алдаа зөрчил илрүүлж, 12,135.1 сая төгрөгийн 15 алдааг залруулж, 71.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 513.3 сая төгрөгийн 31 зөвлөмж хүргүүллээ.

Тайлант оны аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ангилан харуулбал:

- *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 13.6 сая төгрөгийн 16 зөрчил,*
- *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 12.135.1 сая төгрөгийн 15 алдаа, 211.8 сая төгрөгийн 10 зөрчил*
- *Дотоод хяналт, худалдан авалттай холбоотой 359.0 сая төгрөгийн 8 зөрчил байна.*

Үүнээс тайлант онд хугацаа болсон албан шаардлагын хэрэгжилт хангагдаж, 257.5 сая төгрөгийн 15 албан шаардлага, зөвлөмж хэрэгжсэн байна.

Өмнөх оны эхний хагас жилийн статистик мэдээгээр хугацаа хэтэрсэн 6796.8 сая төгрөгийн 23 акт, албан шаардлага, зөвлөмж байсан бол тайлант онд 5606.1 сая төгрөгийн 22 зөвлөмж үлдэгдэлтэй байгаа нь өмнөх үетэй харьцуулахад үлдэгдэл 1190.7 сая төгрөгөөр буюу 17.5 хувиар буурсан байна.

III. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 2 гүйцэтгэлийн аудит хийж дуусгахаар төлөвлөсөн бөгөөд УАГ-ын нэгдсэн удирдамжаар 1 аудит, өөрсдийн санаачилгаар 1 аудитыг хийж гүйцэтгэлээ. Аудитыг 4 аудитор нийт 162 хүн-өдөрт гүйцэтгэж, 64 илүү цаг ажилласан.



3783.6 төгрөгийн 29 зөрчил



4.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт,
2334.0 сая төгрөгийн 7 албан шаардлага,
1.444.8 сая төгрөгийн 20 зөвлөмж

Тайлант хугацаанд хэрэгжвэл зохих 1 төлбөрийн акт барагдсан. Хугацаа болоогүй албан шаардлага болон зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд 4.8 сая төгрөгийн 1 санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн. Үр өгөөжөөр бүртгэсэн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжих хугацаа болоогүй, хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

3.1. Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг /Код: ДГА-2021/06-9-ШТА-ГА, УАГ-ын нэгдсэн удирдамжаар/.

Аудитад тус аймагт 2020 онд улсын төсвөөр хэрэгжсэн ТАХ-г хамруулан, 2020.03.10-2020.05.18-ны хугацаанд гүйцэтгэлээ. Тус аймагт 71.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, 29.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тайлант онд олгохоор шийдвэрлэсэн байна.

Аудитын дүнд үндэслэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд захиалагч, зохиогчийн хяналтын үр дүнг сайжруулах шаардлагатай байна” гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгсөн.

Хөрөнгө оруулалтыг салбарын болон орон нутгийн хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан шат шатанд төлөвлөж байгаа ч үр ашгийг тооцож судлаагүй, хөрөнгө оруулалтаас бий болох үр ашиг, нийгмийн болон эдийн засгийн тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн, зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулагдаагүй ажлыг төлөвлөж батлуулснаас ТАХ гэрээний хугацаанд хийгдээгүй, ажил чанаргүй хийгдэх зөрчил нийтлэг гарсан байна.



2156.7 сая төгрөгийн
13 зөрчил илрүүлж



4.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт
2151.9 сая төгрөгийн 4 албан шаардлага
8 зөвлөмж

Үүнээс 4.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт барагдаж, бусад албан шаардлага болон зөвлөмжийн хэрэгжилтийн хугацаа болоогүй тул хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

IV. НИЙЦЛИЙН АУДИТ

Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд өмнөх оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлж дуусаагүй 1 нийцлийн аудитыг дуусгахаар тусгаснаар гүйцэтгэлийн үе шатны ажлыг дуусгасан, тайлагналын үе шатны ажил хийгдээгүй байсан 1 аудитыг тайлант онд хийж гүйцэтгэсэн.

4.1 Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа /Өөрийн санаачилгаар, код: ДГА-2020/09-НА өөрийн санаачилгаар/

Аудитаар төрийн албаны салбар зөвлөлийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулж тайлагналын үе шатны ажлыг 2021 оны 01 сарын 08-ны өдөр дуусгаж, аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн **“Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна”** гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгсөн.

Аудитаар СЗ-ийн гишүүд нь жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн тайлагнаагүй, ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнээгүй, хариуцлага хүлээлгэх асуудал орхигдсон, нөөцийн бүртгэл хөдөлгөөнийг бүрэн хөтлөөгүй, зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах чиг үүргийн хүрээнд 2019 онд 96, 2020 онд 55 албан хаагчид тус нэмэгдлийг олгуулах саналыг гаргасан байх боловч 2019 оны архивын баримт материалыг гаргаж ирүүлээгүйгээс шаардлага хангасан албан хаагчид олгосон эсэх нь тодорхойгүй, 2020 онд шаардлага хангагдаагүй байхад нэмэгдэл олгосон, 184 сул орон тооны тусгай шалгалтыг зохион байгуулаагүй, ТЖА-ны ажлын байрны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг захиалгын дагуу тухай бүр зохион байгуулаагүйгээс ТЖА-ны нөөцөд бүртгэгдээгүй 47 иргэнийг түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулсан, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй төрийн албан хаагчдыг тусгай шалгалтад оруулж, нэр дэвшүүлэн томилсон зэрэг зөрчил илэрсэн.



8 зөрчил
илрүүлсэн.



8 зөвлөмж хүргүүлэв

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн хугацаа болоогүй тул хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

4.2. Аймгийн болон Замын-Үүд сумын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, иргэн, ААНБ-аас төвлөрүүлсэн хандивын зарцуулалт.

Аудитад аймгийн болон Замын-Үүд сумын Онцгой комиссын 2020 оны санхүүгийн үйл ажиллагааг хамруулан 2021.06.07-2021.06.30 хүртэлх хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.

Шинэ төрлийн Коронавируст цар тахлын үед уг өвчинтэй тэмцэх, хамгаалах үйл ажиллагаанд иргэн, ААНБ-аас мөнгөн болон мөнгөн бус хандив болон тусгаарлагдсан иргэдийн төлбөрийн төвлөрүүлэлт, түүний зарцуулалтад аудит хийгдэж байна. Одоогоор тус аудитын тайлагналын үе шатны ажил явагдаж байна.

V. ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР БОЛОН ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙХ АУДИТ

ИТХ-ын болон өөрийн санаачилгаар хийх аудитын 4 сэдэв батлагдсанаас 2021 оны эхний хагас жилийн байдлаар 1 аудитыг бүрэн хийж дуусах, 2 аудит хийж эхлэхээр төлөвлөгөө батлагдсаны дагуу тайлант хугацаанд 1 аудитыг бүрэн дуусгаж 2 аудитын талбарын буюу гүйцэтгэлийн үе шатны ажил хийгдэж дуусаад тайлагналын үе шатны ажил гүйцэтгэж байна.

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө /Код: ДГА-2021/73-ШТА-ГА, өөрийн санаачилгаар/

Аудитаар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулан 2020.01.02-2020.05.06 хүртэлх хугацаанд гүйцэтгэлээ.

Аймгийн ХЭДС-аас 2019-2020 онд нийт 1595 иргэн, ААНБ-д нийт 1,433.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг орон нутгийн бодлого чиглэлтэй уялдуулан, үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна”** гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгсөн.

Аудитаар Аймгийн ХЭДС-ийн 2019-2020 оны төсвийн төслийг бодит тооцоо, судалгаанд үндэслэж боловсруулаагүй, ХЭДС-ийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг ирүүлсэн төслийг хууль тогтоомжид заасан шалгуур нөхцөлийг бүрэн хангасан эсэхэд анхаарч ажиллаагүй, үйл ажиллагааны зарим баримт бичиг шаардлага хангаагүй, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн байдал хангалтгүй, сангийн хөрөнгийг зориулалт бусаар ашигласан зарим иргэнд холбогдох арга хэмжээг аваагүй, хууль тогтоомжид заасан шалгуур үзүүлэлт хангаагүй зарим төслийг шалгаруулж жижиг зээл олгосон, гэрээний хугацаа дууссан, хугацаа хэтэрсэн эргэн төлөлтийг тухай бүр шийдвэрлээгүй, эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 35 иргэний 67.2 сая төгрөгийн үлдэгдлийг шийдвэрлээгүй, Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл хууль тогтоомжид заасан эрх, үүргээ хэрэгжүүлээгүй, сангийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй зэрэг зөрчил илэрсэн байна.



**1,643.0 сая төгрөгийн
зөрчил илрүүлсэн**



6.0 сая төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлж, 192.2 сая төгрөгийн зөрчил арилгах, хариуцлага тооцох 4 албан шаардлага, 11 зөвлөмж хүргүүлэв

Тус аудитаар илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.

5.2 Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл /Код: ДГА-2021/76-ШТА-ГА, өөрийн санаачилгаар/

Аудитад аймгийн ТЕЗ-ын харьяаны нийт 106 төсөвт байгууллагын 2019, 2020 онуудын түлш, халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг хамруулан, 2021.05.03-ны өдрөөс 2021.06.30-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Аудитын хөтөлбөрт тусгагдсаны дагуу тайлагналын үе шатны ажлыг хэрэгжүүлж байна.

Аудитаар дулаанаар хангах тусгай зөвшөөрөлгүй, дулааны үнэ тарифыг батлуулаагүй ААН дулаан хангах үйл ажиллагааг эрхлэн явуулсан, халаалтын зардлын төсвийг шалгагдагч байгууллагууд үндэслэлгүй тооцож, төлөвлөсөн, зардлыг зориулалт бусаар зарцуулсан, төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын гүйцэтгэлийг зөрүүтэй тусгасан, шалгагдагч байгууллагын эзлэхүүний хэмжээг гэрээнд ихээр тусгасан, нүүрсний ХАА-г хууль журмын дагуу зохион байгуулаагүй зэрэг зөрчил илэрсэн.

5.3 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийх /Өөрийн санаачилгаар, код: ДГА-2021/75-ШТА-ГА/

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2021.05.03-ны өдрөөс эхлэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, асуудлын шинжилгээг боловсруулж, төлөвлөгөөг 2021.05.21 өдөр батлан 2021.06.30-ны өдөр дуусгахаар аудитыг АДБОУС, ТАБ-ын аудит хийх журам зааврын дагуу аудитын нээлтийг хийн гүйцэтгэлийн үе шатны ажлыг дуусган тайлагналын үе шатны шатны ажлыг хэрэгжүүлж байна.

Аудитаар хүний нөөц орон тооны хувьд MNS 5095:2017 стандартыг хангаагүй, ТАЗ-ийн тогтоол болон, Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартыг мөрдөн ажиллаагүйгээс ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулаагүй, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг зохион байгуулахдаа дотоодын үйлдвэрийн эм тариаг хэт цөөн тоогоор багцалсан байна. Мөн хэвтүүлэн эмчлэх орны тоог бодитой тооцоогүй, зарим тасгийн орны эргэлт хангалтгүй, амбулаторын үзлэгийн цаг 15 минутаар тооцсон боловч цаг ашиглалт хангалтгүй, байгууллагын www.dornogovine.mn вэб сайтын ашиглалт хангалтгүй буюу 2020 оны 12 дугаар сараас хойш мэдээлэл оруулаагүй зэрэг алдаа зөрчлүүд илрээд байна.

VI. ДОТООД АЖИЛ

6.1 Дотоод сургалт

Бүтэц зохион байгуулалтын шинэчлэлийн хүрээнд байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг албан хаагчдаас ирүүлсэн санал, тэдний ур чадвар, чадахыг сайжруулах хэрэгцээ шаардлага болон ҮАГ-ын сургалтын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, дарга, тэргүүлэх аудитораар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төлөвлөгөөнд байгууллагын албан хаагчдаас зохион байгуулах 13 сургалт, сургалтын мэргэжлийн байгууллага, багштай хамтран зохион байгуулах 1 сургалтыг тусгаж, тайлант хугацаанд зохион байгуулах төлөвлөгөөт сургалтыг бүрэн явуулсан. **Үүнд:**

1. ХАСХОМ мэдүүлэх
2. Үр өгөөжийн бүртгэл, төлөвлөлт
3. Цаг ашиглалт
4. Байгууллагын соёл
5. Гүйцэтгэлийн аудитад нотлох зүйлийг үнэлэх, дүн шинжилгээ хийх заавар



Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас танхимын сургалт явуулах боломжгүй болсон тул дотоод сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан зарим сургалтыг цахимаар явуулж эхлээд байна.

Байгууллагын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дотоод сургалтаас гадна дараах сургалтад хамрагдан мэдлэг чадвараа дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна. Үүнд:

- Сангийн яамнаас зохион байгуулсан “Засгийн газрын худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох” цахим сургалтад аудитын менежер болон 5 аудитор хамрагдаж, АЗ гэрчилгээ авсан.
- Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт цахим сургалтад дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер болон 4 аудитор хамрагдаж, амжилттай суралцсан.
- ММНБИ-ээс зохион байгуулсан “Мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалт”-д дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер болон 2 ахлах аудитор, 2 аудитор хамрагдаж, мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлсэн.
- Удирдлагын Академиас зохион байгуулсан “Алсын хараа-2050” сэдэвт цахим сургалтад дарга, тэргүүлэх аудитор болон аудитын менежер нар хамрагдаж, гэрчилгээ гардан авсан.
- “Тод” санхүү, бизнесийн академиас зохион байгуулсан “Өртөг ба гүйцэтгэлийн удирдлага” цахим сургалтад аудитор Ч.Хэрлэнчимэг 2 сарын хугацаанд хамрагдсан.
- Удирдлагын Академийн Төрийн удирдлагын магистрын ангид аудитор Ч.Хэрлэнчимэг суралцаж байна.
- УАГ-аас зохион байгуулсан “Хуулийн хэрэглээ /Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга/” сэдэвт цахим сургалтад 2 албан хаагч хамрагдаж, амжилттай суралцсан.
- УАГ-аас зохион байгуулсан “Төрийн аудитын суурь ойлголт, стандартын хэрэглээ” сэдэвт цахим сургалтад 2 албан хаагч хамрагдаж, амжилттай суралцсан.
- УАГ-аас зохион байгуулсан шилэн дансны цахим систем болон статистик мэдээ, бүртгэл, нэгтгэлийн системийн тухай ойлголт, МУЕА-ын шинээр баталсан дүрэм, журмын танилцуулгын талаарх мэдээлэл өгөх сургалтуудад байгууллагын бүх албан хаагчид хамрагдсан болно.

6.2. Архив, бичиг хэрэг

Тус байгууллагад 2021 оны эхний хагас жилд нийт 399 албан бичиг ирж, бусад байгууллага албан тушаалтанд 429 албан бичгийг хүргүүлсэн байна. Тайлант хугацаанд ирсэн болон явсан албан бичгийг тухай бүрд нь бүртгэн сканердаж able программд оруулан, холбогдох албан тушаалтанд танилцуулан шийдвэрлэн ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагаа болон хүний нөөцтэй холбоотой “А” тушаал 17, “Б” тушаал 5 гарсан.

- Ирсэн болон явсан бичгийн хариу ирүүлэх хугацааг able программд тэмдэглэж, хяналт тавин ажиллаж байна.

- Ирсэн болон явсан бичгийг бичиг хэргийн ажилтан тухай бүр сканердаж, цахим сан /архив/ үүсгэн ажиллаж байна.

Байгууллагын албан хэрэг хөтлөх үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэх зорилгоор БНШКомисс хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, аймгийн Архивын газраар батлуулсан.

6.3. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа

Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор 1 ширхэг зөөврийн компьютер, 1 ширхэг суурин компьютер, 1 ширхэг 3 үйлдэлт принтер худалдан авсан.

ТАБ-ын Хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн аудитор Ч.Хэрлэнчимэгт магистрын сургалтын төлбөрийн хөнгөлөлт, аудитор Б.Уранбилэгт орон сууцны нөхцөлөө сайжруулахад мөнгөн дэмжлэг, шинэ хүүхэдтэй болж, ам бүл нэмсэн аудитор Л.Равдандоржид нэг удаагийн буцалтгүй тусламжийг тус тус олгож, албан хаагчдын зарим нийгмийн асуудлыг төсвийн хүрээнд шийдвэрлэсэн.

Жил бүр тохиох Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болон Шинэ жилийн баяраар байгууллагын албан хаагчдын үр хүүхдүүдэд бэлэг гардуулж заншсан ба тайлант оны 6 дугаар сарын 1-нд албан хаагчдын 24 хүүхдэд бэлэг гардуулсан.

Албан хаагчид өөрсдийн мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор суралцсан албан хаагчдад байгууллагаас сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал, “Мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалт”-д хамрагдсан 5 албан хаагчдад тус бүр 40.0 мянган төгрөгийн, Засгийн газрын худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох” сургалтад хамрагдаж, амжилттай суралцсан 5 албан хаагчдад тус бүрд сургалтын төлбөр болох 70.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Байгууллагын албан хаагчдын чөлөөт цагийг зөв, үр бүтээлтэй өнгөрүүлэх үүднээс 7 хоног бүрийн Мягмар гарагт гар бөмбөг, сагсан бөмбөгийн спортоор хичээллэж байна. /Ковид-19 цар тахлын тархалттай холбоотойгоор уг үйл ажиллагаа түр завсарлаад байна/.

Мөн ТАГ-ын байрладаг албан байранд зэрэгцэн ажиллаж байгаа Байгаль орчин аялал жуулчлалын газар, Санхүүгийн хяналт, аудитын албаны албан хаагчдын дунд нөхөрсөг гар бөмбөгийн тэмцээнийг ТАГ-аас зохион байгуулж, тэргүүн байр эзэлсэн.

Мөн Ковид-19 цар тахлын тархалт ихэссэн энэ хүнд үед албан хаагчдыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Верацелл вакциныг 2 тунд хамруулж, 1, 6 дугаар саруудад 2 удаа витаминжуулж, дархлааг дэмжих арга хэмжээ авч ажиллаад байна.



6.4. Хүний нөөц, шагнал урамшуулал

Тус байгууллагад шинээр томилогдсон аудитор Д.Дэмбэрэлсүрэн, Б.Ариунбаатар нар ТАБ-ын хэмжээнд зохион байгуулагдсан “ТАБ-ын ажилтны тангараг өргөх ёслол”-д оролцож, Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн тангаргийг өргөлөө.



6.5. Дотоод зохион байгуулалтын бусад асуудал

- Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд нийт алба хаагчдаас Үндэсний аудитын газрын өгсөн чиглэлийн дагуу 2020 оны ХАСХОМ-ыг 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор гаргуулан, хуульд заасан хугацаанд тайланг баталгаажуулсан. Мөн 2-р улиралд шинээр томилогдсон аудитор Д.Дэмбэрэлсүрэнгийн ХАСХОМ-ыг гаргуулан системд баталгаажуулсан.
- УАГ-ын ерөнхий ЭБАТ-ын өгсөн чиглэлийн дагуу 2021 оны 06-р сарын 15-ны дотор авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлын хагас жилийн тайланг 2021 оны 06 сарын 14-ний өдөр хүргүүлсэн.
- УАГ-ын audit.mn цахим хуудаст төрөлжсөн аудитын 136 тайлан, өдөр тутмын үйл ажиллагаа, мөн байгууллагын мэдээллийн самбарт санхүүгийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитын албадын тайлант онд хийсэн аудитын талаарх товч мэдээллүүдийг тогтмол шинэчлэн ажиллуулж байна.
- УАГ-ын бүхий төлөвлөгөөг боловсруулан, үүний дагуу аудитын үе шат бүрд хэрэгжүүлэн ажиллаж байна.

6.6. Шинэ санал, санаачилга.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар 2021 онд дараах ажлуудыг шинээр санаачлан хэрэгжүүллээ. Үүнд:

- Өөрийн санаачилгаар хийх аудитын төлөвлөгөө хөтөлбөр боловсруулахтай холбоотойгоор аудитор бүр сэдэвтэй холбоотой 3 эрсдэл тодорхойлон үнэлж, төлөвлөгөө, хөтөлбөр, асуудлын шинжилгээнд аудитор бүрийн оролцоог ханган ажилласнаар хуваарьт аудитаас гадна бусад аудитын талаар мэдээлэл мэдлэгтэй болж байна.
- Мөн 2022 онд өөрийн санаачилгаар хийх аудитын сэдэв сонгох ажлын хүрээнд аудитор бүр 3 сэдвийн судалж, дүн шинжилгээ хийн, дүгнэлт боловсруулан хамрах хүрээ, үндэслэлийг гаргахаар ажиллаж байна.
- Аудит хийсэн баг аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг аудиторуудад танилцуулан хэлэлцүүлэг явуулах замаар зөвлөмж, албан шаардлагыг тогтоодог болсноор гарч буй зөвлөмж, албан шаардлага дүгнэлттэй уялдаа холбоотой, биелэгдэхүйц болж байна.

VII. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСӨВ ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан мэдээ.

Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан мэдээ. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журмын дагуу хөтөлж, 2019 оноос НББ-ийн үйл ажиллагаанд “Unicus” программыг ашиглаж байна.

Тайлант оны эхний хагас жилд 233.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 230.9 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 164.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд аудитын үйлчилгээний төлбөрт нийт 51.0 сая төгрөг төвлөрч, ХБАК-дад 44.8 сая төгрөг шилжүүлээд байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, татвар, НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь тогтмол байршуулан, илгээж байна. Байгууллагын хөрөнгийн хагас жилийн тооллогыг зохион байгуулахаар Тэргүүлэх аудиторын 2021 оны А/18 тоот “Эд хөрөнгийн тооллого явуулах тухай” комисс байгуулаад байна.

2020 оны санхүүгийн тайланд “Мишээл-Од аудит” ХХК аудитыг хийж гүйцэтгэн “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн. Аудитын тайланд 7.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн хэрэгжилтийг хүргүүлсэн.

VIII. ДҮГНЭЛТ, САНАЛ

8.1. Дүгнэлт

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлт. Үүнд:

- ТАГ нь 2021 онд нийт 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс эхний хагас жилд хэрэгжүүлж дуусах 12 арга хэмжээг төлөвлөсөн хугацаандаа бүрэн гүйцэтгэсэн байна.
- Тайлант оны эхний хагас жилд санхүүгийн тайлангийн 206 аудит, гүйцэтгэлийн 2, нийцлийн 1 аудитыг холбогдох хууль, журам, стандартын дагуу хийж гүйцэтгэлээ.
- Аудитаар нийт 50,857.3 сая төгрөгийн 776 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 37,278.7 сая төгрөгийн 413 алдаа зөрчлийг залруулж, 27.5 сая төгрөгийн зөрчилд 21 төлбөрийн акт тогтоож, 5,594.0 сая төгрөгийн зөрчилд 74 албан шаардлагыг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.
- Мөн 7952.4 сая төгрөгийн зөрчилд 264 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 3 албан шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн, 4.7 сая төгрөгийн зөрчилтэй 1 байгууллагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх саналыг МУ-ын Ерөнхий аудиторт хүргүүлсэн.
- Тайлант оны эхний хагас жилд хэрэгжвэл зохих 26.1 сая төгрөгийн 19 төлбөрийн актын биелэлт 73.7 хувь, 2560.2 сая төгрөгийн 32 албан шаардлагын биелэлт 93.8 хувь, 5807.8 сая төгрөгийн 99 зөвлөмжийн хэрэгжилт 60.0 хувьтай байна.
- Мөн өмнөх оны үлдэгдэл 17.7 сая төгрөгийн 19 төлбөрийн актаас 0.9 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 5184.3 сая төгрөгийн 14 албан шаардлагаас 186.9 сая төгрөгийн 3 албан шаардлага тайлант хугацаанд хэрэгжсэн.
- Тайлант онд хугацаа хэтэрсэн 15,741.6 сая төгрөгийн 189 акт, албан шаардлага, зөвлөмж үлдэгдэлтэй байгаа нь өмнөх үетэй харьцуулахад үлдэгдэл 1,329.5 сая төгрөгөөр буюу 8.0 хувиар буурсан байна.
- Тайлант хугацаанд орон нутгийн төсөвт нийт 11.0 сая төгрөгийг төвлөрүүлэн, 11.0 сая төгрөгийн 19 санхүүгийн үр өгөөж, санхүүгийн бус 1 үр өгөөжийг тус тус хүлээн зөвшөөрүүлж ажилласан.

8.2. Санал

1. Төрийн аудитын стандартын онлайн сургалтад бүх аудиторуудыг бүрэн хамруулах
2. Өр өгөөжийн бүртгэлээр танхимын сургалтад хамрагдах
3. Нэгдсэн удирдамжаар хийгдэх аудит эхлэхийн өмнө мэдээлэл сургалтыг тогтмол зохион байгуулах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

Маягт: УАГ 1135

Хавсралт №5

АУДИТЫН ҮР ӨГӨӨЖИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

2021.06.25

№	Тайлант жил: 2021 оны эхний хагас жил		Аудитын менежер: У.Оюунтүлхүүр			
	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар		Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий			
	1130 маягтын дугаар	Аудитын нэр /код	Аудитын үр өгөөжийн товч утга	Үр өгөөжийн нийт үнэлгээ, мянган төгрөг		Тайлбар
1	1	Өргөн сумын ЗДТГ /ДГА-2021/51/СТА-ТШЗ/	Цалин хөлсийг ээлжийн амралтын олговортой дахцуулж олгосныг төлүүлэх тухай	0.08	2021	05/A1060293/ДГА-2021/51/СТА-ТШЗ
2	2	Дэлгэрэх сумын ЗДТГ /ДГА-2021/26/СТА-ТШЗ/	Анхан шатны баримтгүйгээр томилолтын зардал олгосныг төлүүлэх тухай	0.16	2021	03/A1060293 ДГА-2021/26/СТА-ТШЗ
3	3	Дэлгэрэх сумын ЗДТГ /ДГА-2021/26/СТА-ТШЗ/	Дутуу суутгасан цалингийн урьдчилгааг төлүүлэх тухай	0.17	2021	04/A1060293/ДГА-2021/26/СТА-ТШЗ
4	4	Прокурорын газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудит /ДГА-2021/133/СТА-ТШЗ/	Албан томилолтоор болон цалинтай чөлөөтэй байсан 9 албан хаагчид хоолны хөнгөлөлтийг давхардуулж олгосон байна.	0.10	2021	01/63 ДГА-2021/133/СТА-ТШЗ
5	5	Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудит /ДГА-2021/134/СТА-ТШЗ/	Албан томилолтоор болон цалинтай чөлөөтэй байсан 7 албан хаагчид хоолны хөнгөлөлтийг давхардуулж олгосон байна.	0.11	2021	01/62 ДГА-2021/134/СТА-ТШЗ
6	7	Зэвсэгт хүчний 281-р байгууламжийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудит /ДГА-2021/16/СТА-ТШЗ/	Тайлант оны 12 дугаар сард ажиллагсдаас орон сууцны түрээс болон цахилгаан ашиглалтын төлбөр болох 529,880 /таван зуун хорин есөн мянга найман зуун наян/ төгрөгийг суутгаж аваагүй байна.	0.50	2021	09/A1070298 ДГА-2021/16/СТА-ТШЗ
7	8	Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудит /ДГА-2021/92/СТА-ТШЗ/	Тайлант онд орон нутгийн өмчийн орон сууц түрээслүүлсний орлого нийт 9,569.493 /есөн сая таван зуун жаран есөн мянга дөрвөн зуун ерэн гурван/ төгрөгийг бүрдүүлсэн боловч 4,353.296 /дөрвөн сая гурван зуун тавин гурван мянга хоёр зуун ерэн зургаан/ төгрөгийг орон өмчийн дансанд шилжүүлж, 431.450 /дөрвөн зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун тавин/ төгрөгийг дутуу шилжүүлсэн байна.	0.20	2021	08/A1070298 ДГА-2021/92/СТА-ТШЗ

№	1130 маягтын дугаар	Аудитын нэр /код	Аудитын үр өгөөжийн товч утга	Үр өгөөжийн нийт үнэлгээ, мянган төгрөг		Тайлбар
8	9	Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит /ДГА-2021/111/СТА-ТШЗ/	Нотариатын орлого орон нутгийн дансанд төвлөрүүлээгүй	0.30	2021	12/A1070297 ДГА-2021/111/СТА-ТШЗ
9	10	Зэвсэгт хүчний 253 дугаар тусгай ротын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит /ДГА-2021/22/СТА-ТШЗ/	Төлбөр барагдуулах тухай /албан хаагчдаас суутган авсан орон сууцны мөнгийг зарцуулсан анхан шатны баримт байхгүй/	0.22	2021	07/A1070299 ДГА-2021/22/СТА-ТШЗ
10	11	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит /ДГА-2021/148/СТА-ТШЗ/	ЖА тэтгэмж олгохдоо дундаж цалинг илүү тооцсон	0.03	2021	13/A1070297 ДГА-2021/148/СТА-ТШЗ
11	12	Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит /ДГА-2021/111/СТА-ТШЗ/	Ээлжийн амралтын дундаж цалин, хөлсөнд унаа хоолны хөнгөлөлтийг оруулан бодсон	0.27	2021	11/A1070297 ДГА-2021/111/СТА-ТШЗ
12	13	Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит /ДГА-2021/35/СТА-ТШЗ/	Төлбөр барагдуулах тухай /1 ажилтнаас цалингийн урьдчилгааг суутгаагүй/	0.30	2021	15/A1070299 ДГА-2021/35/СТА-ТШЗ
13	14	Хилийн 0108 дугаар ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит/ ДГА-2021/104/СТА-ТШЗ/	Сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчийн шийтгэлийг цалингаас суутган тооцоогүйгээс цалин хөлсийг илүү тооцож, 62.7 мянган төгрөгийг 2 албан хаагчид илүү олгосон байна. Мөн ээлжийн амралтын олговрыг тооцохдоо дундаж цалин хөлсний дүнд унаа, хоолны хөнгөлөлтийг нэмж тооцон, 258.7 мянган төгрөгийг 7 албан хаагчдад илүү олгосон байна	0.32	2021	01/64 ДГА-2021/104/СТА-ТШЗ
14	15	Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн /ДГА-2021/143/СТА-ТШЗ/	Төлбөр барагдуулах тухай/ ээлжийн амралтыг олговор 1 ажилтанд зөрүүтэй тооцсон, 6 ажилтнаас сахилгын шийтгэл тооцоогүй/	2.18	2021	14/A1070299 ДГА-2021/143/СТА-ТШЗ
15	18	Хилийн цэргийн 129-Р АНГИ /ДГА-2021/105/СТА-ТШЗ	Цалин хөлсийг ээлжийн амралтын олговортой дахцуулж олгосныг төлүүлэх тухай	0.23	2021	01/65 ДГА-2021/105/СТА-ТШЗ

№	1130 маягтын дугаар	Аудитын нэр /код	Аудитын үр өгөөжийн товч утга	Үр өгөөжийн нийт үнэлгээ, мянган төгрөг		Тайлбар
16	19	Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг /ДГА-2021/06-9-ШТА-ГА/	Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой	4.78	2021	17/A1060293 ДГА-2021/06-9-ШТА-ГА
17	20	Зэвсэгт хүчний 253 дугаар тусгай ротын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит /ДГА-2021/22/СТА-ТШЗ/	Зөрчлийг арилгах тухай /Нүүрс бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж, бодитоор хүлээн аваагүй байгаа нүүрсийг авах/	0.20	2021	2021.03.04, 41/A1070299 ДГА-2021/22/СТА-ТШЗ
18	43/2020	Дэлгэрэх ЗДТГазар	Төлбөрийн акт тогтоох тухай	0.20	2020	05/25 ДГА-2020/26/СТА-ТШЗ
19	44/2020	Өргөн сумын ЗДТГ	Төлбөрийн акт тогтоох тухай	0.40	2020	01/29 ДГА-2020/51/СТА-ТШЗ
20	45/2020	Өргөн сумын ЗДТГ	Төлбөрийн акт тогтоох тухай	0.20	2020	02/30 ДГА-2020/51/СТА-ТШЗ
		НИЙТ		11.0		